



ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЭНХЖАРГАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.10 № 01/10 ДУА-2017/71/СТА-ТЦЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Луус сумын Засаг даргын Тамгын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 204,500.00 /Хоёр зуун дөрвөн мянга таван зуу/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Луус сумын Засаг даргын Тамгын газар нь 78,500 /Далан найман мянга таван зуун /төгрөгийн гар утасны нэгжийн төлбөрийг төсвөөс олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/, Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 47-р тогтоолын 2.2-д /албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх/.

2. Насжилт өндөртэй 126,000.00 / Нэг зуун хорин зургаан мянган / төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 20 дугаар зүйл 20.2.6-т /Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ гэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн / 4.1.4-т /Байгууллага, иргэдтэй үүссэн материаллаг дүнтэй буюу насжилт өндөртэй авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй/ гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

0000000022

1. Төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах, хэмнэлтийн горимд шилжих, шинээр гарсан тогтоол, журмыг мөрдлөг болгон ажиллах,
2. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж, насжилт өндөртэй авлагыг барагдуулах, хууль, хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2017 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлэхийг Луус сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Энхжаргал/, нягтлан бодогч /Б.Доржханд/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:


ШИНЖЭЭЧ



С.ЖАЛБАА

ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА



Б.ЭНХЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ

Б.ДОРЖХАНД

¹ Акт, албан шаардлагын биелэлт ханаагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.